



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/443

Чингис хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 2.1.6, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн 2020 оны төсөв батлах тухай" 2019 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн боловсрол, соёлын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулахад Боловсрол, соёл, урлагийн газарт дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 752760 /долоон зуун тавин хоёр мянга долоон зуун жар/ төгрөгийн хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010743